



for a living planet[®]

**Цоохор ирвэс (*Uncia uncia*) хамгаалал, хуулийн
хэрэгжилтийн талаарх Монголын Алтай Соёны
ард иргэдийн мэдлэгт өгсөн үнэлгээ**



Ё.Онон, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Л.Алтанцэцэг, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны салбар

С.Баярхүү, Монголын Ирвэс төв

УЛААНБААТАР ХОТ

2006 ОН

Гарчиг

Өмнөх үг (судалгаа хийх үндэслэл, шаардлага, зорилго)3

Судалгааны зорилго..... 4

Судалгааны материал, арга зүй:..... 5

Судалгааны ажлын үр дүн5

1.Говь-Алтай аймаг 5

2.Ховд аймаг 8

3.Увс аймаг 11

4.Баянхонгор аймаг 13

5.Баян-Өлгий аймаг..... 15

Дүгнэлт18

Зөвлөмж21

Өмнөх үг (судалгаа хийх үндэслэл, шаардлага, зорилго)

Монгол оронд 1990-ээд оноос эхлэн нэн ховор болон ховор зүйлүүдийг хамгаалах нилээд олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжсэн. Хэрэв тэдгээр төсөл, хөтөлбөр хэрэгжээгүйсэн бол нэн ховор амьтны жагсаалт өнөөдөрийнхөөс хэд дахин урт байхыг хэн ч үл мэднэ.

Тэдгээр төсөл хөтөлбөрийн нэг нь Алтай Соёны бүс нутагт хэрэгжсэн Цоохор ирвэс хамгаалах төсөл юм. Энэ зүйл амьтныг хамгаалахад Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Монголын Ирвэс төвөөс урт болон богино хугацааны төслүүд, Нэгдсэн үндэсний байгууллага Байгаль орчны яамнаас Монголын Алтай соёны өндөр уулын экосистемийг ард иргэдийн оролцоотой хамгаалах төслийг хэрэгжүүлж байна.

Судлаачдын тогтоосноор Монгол оронд ойролцоогоор 700-1500 орчим цоохор ирвэс байна. Энэ нь цоохор ирвэсний дэлхийн популяцийн 13-22% нь Монгол оронд байна гэсэн үг. Цоохор ирвэсний гол тархац нутаг нь Монгол орны баруун ба баруун урд хэсэг юм.

Цоохор ирвэсний экологи, хамгааллын талаар тухайн нутагт амьдардаг ард иргэд ямар ойлголттой байна цаашид ямар арга замаар байгаль хамгаалалын сурталчилгааг явуулах вэ гэдэгт хариулт авах нөгөөтэйгүүр Монгол улсад нүүрлээд байгаа ан амьтны гаралтай түүхий эдийн хууль бус худалдаа цоохор ирвэсний хувьд ямар түвшинд байгааг тандаж тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийсэн болно. Судалгааг Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгийн цоохор ирвэс бүхий нутгийн иргэдийн дунд зохион байгуулсан.

Товчилсон үгсийн тайлбар

CITES- Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон төрөл зүйлийг хамгаалах олон улсын конвенци

НҮБ- Нэгдсэн үндэсний байгууллага

БОЯ- Байгаль орчны яам

ДБХС- Дэлхийн байгаль хамгаалах сан

Талархал

Юуны өмнө энэхүү судалгааны мэдээг цуглуулахад оролцсон Баян-Өлгийн аймгийн Боловсрол соёлын газрын Байгалийн ухааны арга зүйч М.Саветхан, ахлах 3 дугаар сургуулийн химийн багш Х.Данагуль, Говь-Алтай аймгийн Боловсрол соёлын газрын Байгалийн ухааны арга зүйч Ц.Цэцэгмаа, Баянхонгор аймгийн Боловсрол соёлын газрын сургалтын менежер М.Мөнхбат болон уг судалгаанд оролцож чин сэтгэлээсээ хариулж тусалсан бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Судалгааны зорилго

Судалгааг 2006 оны 7-9 саруудад хийсэн.

Энэхүү судалгааны ажил нь цоохор ирвэсний гол тархац нутагт амьдарч буй нутгийн иргэдийн энэ зүйл амьтны экологи, хууль эрх зүйн мэдлэгийг ямар түвшинд байгааг тогтоож үнэлгээ өгөх зорилготой. Үүнд дараах үйл ажиллагааг явууллаав .

1. Судалгааны хуудсыг боловсруулж, судалгаа авах арга зүйгээ боловсруулах
2. Боловсруулсан арга зүйн дагуу судалгааг хийх (Хавсралт 1)—
3. Цуглуулсан материалд дүн шинжилгээ хийж дараах асуудлуудыг тодруулна. Үүнд:
 - А. Цоохор ирвэсний биоэкологийн талаар
 - Б. Цоохор ирвэсийг хамгаалах хуулийн хэрэгжилтийн талаар

Нутгийн иргэд “Цоохор ирвэс хамгаалах” гэсэн төслийн нэрнээс нь эхлэн өөрсдөд нь үл хамаарах байдлаар ханддаг талтай. Гэрийн мал цоохор ирвэсэнд өртдөг гэсэн утгаар нь энэ зүйл амьтныг нутгийн иргэд төдийлэн сайнаар хүлээж авдаггу тохиолдол бий .

Аливаа ан амьтныг хамгаалах төсөл, хөтөлбөрт тухайн зүйл амьтны амьдрах орчинд амьдардаг нутгийн иргэд, байгалийн нөөцийг зохистой ашиглах, тогтвортой хөгжлийн үндэсийг бий болгох асуудал заавал тусгагддаг. Тухайлбал ихэнх төслүүд цоохор ирвэсний амьдрах орчинд хүний шууд болон шууд бус сөрөг нөлөөг бууруулах зорилтыг хэрэгжүүлдэг.

Судалгааны материал, арга зүй:

Энэхүү судалгааны ажлыг эхлэхээс өмнө цоохор ирвэсийн гол тархац нутаг дахь байгаль хамгааллын ажлын үр дүнд чухал ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадахуйц бүлгүүдийг тодорхойлогдсон билээ. Эдгээр бүлгийн 834 иргэнээс үндсэн материал болох санал асуулгаа авсан.

Судалгаанд асуулга, харилцан яриа, задлан шинжилгээ, харьцуулан дүгнэлт хийх зэрэг аргуудыг голлон ашигласан бөгөөд боловсруулах явцад биостатистик болон компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэв. Санал асуулгын хуудсыг хавсралт 1-ээр үзүүлэв


Судалгааны ажлын үр дүн

Судалгааны ажлын үр дүнг аймаг тус бүрээр дор гаргав. Үүнд:

1.Говь-Алтай аймаг


Судалгаанд тус аймгийн Чандмань, Төгрөг, Цогт, Шарга, Бугат, Дэлгэр, Халиун, Тонхил, Дарви, Хөх морьт, Баян-Уул сумын 300 иргэн хамрагдсан

Зураг 1. Судалгаанд хамрагдсан газар нутаг



Судалгаанд хамрагдсан иргэдийн 65% хувь нь энэ зүйл амьтны амьдрах орчинтой жилийн 4 улиралд тодорхой хэмжээгээр давхцдаг байна. Эдгээр хүмүүсийн 44.8% нь өвлийн улиралд, 8,2% нь хаврын улиралд, 31,9% нь зуны улиралд, 15% нь намрын улиралд цоохор ирвэсний амьдрах орчинтой гэрийн мал давхцдаг гэж үзжээ. Тиймээс өвлийн улиралд гэрийн мал өртөх нь илүү их байж болно.

График 1.




Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 69% сүүлийн 3 -5 жилд нь цоохор ирвэсний тоо толгой өссөн, 31% хэвийн буюу өсөөгүй гэж үнэлжээ (Диаграмм 1).



Судалгаанд оролцогчдын 69% нь цоохор ирвэсний тоо толгой өссөн гэсэн дүгнэлтийг хийсэн боловч гэрийн малд нөлөөлөх байдалд өгсөн үнэлгээнээс үзвэл нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 48% нь цоохор ирвэсний үндсэн идэш тэжээл болох янгир ямааны тоо толгой буурсан учраас малд халддаг болсон, 30% нь амвдрах орчинд нь малын тоо толгой хэт өссөн гэсэн дүгнэлтийг хийсэн байна (График 2).

График 2




Тус аймгийн судалгаанд хамрагдсан иргэдээс 95.3% нь экологид ямар ач холбогдолтойг мэддэггүй мөртлөө хамгаалах нь зүйтэй гэж үнэлжээ.

Бид судалгааны материал боловсруулах явцдаа ирвэс малд халдах шалтгаануудыг харьцуулж үзэхэд малын тоо нэмэгдэх нь 58.5% байхад тоо толгой нь нэмэгдсэн гэсэн үзүүлэлт 41.5% байна.

Харин янгир ямааны тоо толгой буурах шалтгаануудыг харьцуулан үзвэл малын тоо нэмэгдэх нь 33.7% байхад цоохор ирвэсний тоо толгой нэмэгдсэн гэсэн үзүүлэлт 66.3% байгаа юм.

График 3



Говь-Алтай аймагт цоохор ирвэсний эд, эрхтэний аль нэг хэсгийг ашиглаж ирсэн хэмээн 48.3%, хэрэглэдэггүй гэж 51.7% нь үзжээ.


Говь-Алтай аймгаас судалгаанд оролцогчдын 7.9% нь цоохор ирвэсийг агнахыг хуулиар хориглодог гэж үзэж байхад үлдсэн 92% нь агнах зөвшөөрөл

хэрэгтэй гэж хариулсан. Тус аймгаас судалгаанд хамрагдсан иргэд агнуурын зөвшөөрөл болон агнах хугацааны талаар огт мэдлэггүй байна.

2.Ховд аймаг


Судалгаанд тус аймгийн Үенч, Цэцэг, Чандмань, Манхан, Зэрэг сумын 176 иргэн хамрагдсан (Зураг 2).

Зураг 2. Судалгаанд хамрагдсан газар



Ховд аймгаас судалгаанд хамаарагдсан нутгийн иргэдийн 107 буюу 79% нь цоохор ирвэсний амьдрах орчинтой жилийн 4 улиралд ямар нэгэн хэмжээгээр давхцдаг. Судалгаанд оролцсон хүмүүсийн 41.8% нь өвлийн улиралд цоохор ирвэсний амьдрах орчинд ойр нутагладаг бол намрын улиралд 4.9% буюу хамгийн хол намарждаг байна. Жилийн 3 улиралд нь малын бэлчээр, цоохор ирвэсний ареал хоёр давхцаж байгаа учраас цоохор ирвэсний амьдрах орчны доройтол, малд халдах байдал эрсдэлтэй нөхцөлд байна гэсэн дүгнэлтийг хийж болно. Хүний нөлөөлөх байдлыг улирлаар харуулав (График 4).

График 4




Мөн нийт оролцогчдын 71% нь цоохор ирвэс уствал байгальд дараах хор холбогдол бий болно гэсэн хариулт өгчээ. Үүнд:

- **Экологийн тэнцвэр алдагдана.**
- **Мэрэгч амьтан ихсэж бэлчээрт муугаар нөлөөлнө.**
- **Устгаж болохгүй тодорхой хэмжээгээр агнах хэрэгтэй**
- **Малын өвчин ихэснэ.**
- **Хараалтай амьтан.**
- **Улаан номонд орсон** гэж хариулсан боловч **яагаад** гэсэн учир

шалтгаанд нэг ч хүн тайлбарлаагүй байгаа нь хүмүүст цоохор ирвэсийг хамгаалахын ач холбогдол, учир шалтгааныг энгийнээр тайлбарлан ойлгуулах арга зүй бий болгох шаардлагатайг харуулж байна.


Цоохор ирвэсний тоо толгойн байдалд анализ хийж үзэхэд судалгаанд хамрагсдын 64.8% нь өсөж байгаа гэж хариулсан бөгөөд 35.2% өсөөгүй гээд сүүлийн 5 жилд мал барих болсон гэж 64.2% нь үзэж байна. Цоохор ирвэс малд халдаж байгаа шалтгааныг судалгаанд оролцогчдын 56% нь идэш тэжээлийн хомсдлоос, 22.8% нь тоо толгой нь эрс нэмэгдсэн учраас, 21% нь малын тоо толгой өссөнтэй холбоотой гэж үзжээ (График 5).

График 5



Харин янгир ямааны тоо толгой цөөрч байгаагийн учрыг 55.5% нь хүний нөлөөгөөр тархац нутаг нь хумигдсан, 44.4% нь махчин амьтдын тоо толгой нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна (График 6).

График 6



Цоохор ирвэс малд халдах шалтгаануудыг талбарлсан дүнг харьцуулж үзэхэд малын тоо нэмэгдэх нь 48.1% байхад тоо толгой нь нэмэгдсэн гэсэн үзүүлэлт 51.9% байна.

Харин янгир ямааны тоо толгой буурах шалтгаануудыг харьцуулан үзвэл малын тоо нэмэгдэх нь 55.5% байхад цоохор ирвэсний тоо толгой нэмэгдсэн гэсэн үзүүлэлт 44.4% байгаа юм.


Ховд аймагт цоохор ирвэсний эд, эрхтэний аль нэг хэсгийг ашиглаж ирсэн гэж 42.7 %, огт хэрэглэж байгаагүй гэж 57.3% нь үзжээ.

Судалгаанд оролцогчдын 36.6 % нь цоохор ирвэсийг агнаж болохгүй гэж үзэж байхад үлдсэн 63.3% нь агнахад зөвшөөрөл хэрэгтэй гэж хариулсан.

3. Увс аймаг

Судалгаанд тус аймгийн Бөхмөрөн сумын 34 иргэн хамрагдан оролцсон.

Зураг 3. Судалгааанд хамрагдсан газар



Увс аймгаас судалгаанд хамрагдсан нутгийн иргэдийн 82% нь цоохор ирвэсний амьдрах орчинтой ямар нэгэн байдлаар давхцдаг. Судалгаанд оролцсон хүмүүсийн 54.8% нь зуны улиралд улиралд цоохор ирвэсний амьдрах орчинд ойр нутагладаг бөгөөд бусад улиралд ч мөн адил цоохор ирвэстэй газар хаваржиж, намаржин, өвөлждөг (График 6).


График 6



Судалгаанд оролцогчдын 79.4% нь цоохор ирвэс уствал “**экологийн тэнцвэр алдагдана**” гэж хариулжээ. Харин яагаад гэсэн учир шалтгаанд нэг ч хүн тайлбарлаагүй байна.


Увс аймгийн Бөхмөрөн суманд цоохор ирвэсний тоо толгой өсөж байгаа гэж 73.9% нь сүүлийн 5 жилд мал барих болсон гэж 65% нь үзэж байна. Цоохор ирвэс малд халдаж байгаа шалтгааныг судалгаанд оролцогчдын 46% нь идэш тэжээлийн хомсдлоос, 36.4% нь тоо толгой нь эрс нэмэгдсэн учраас, 18% нь малын тоо толгой өссөнтэй холбоотой гэж үзжээ (График 7).

График 7



Тус аймагт янгир ямааны тоо толгойн байдлыг тандсан судалгааны үр дүнг график 8-д үзүүлэв. Асуулгад оролцогчдын 74% нь малын тоо толгой нэмэгдсэн учраас янгир ямааны тоо цөөрсөн гэж үзсэн байхад махчин амьтдын тоо толгой олширсон хэмээн 26% нь хариулсан байна.

График 8




Судалгаанд хамрагдсан хүмүүс цоохор ирвэсийг агнахыг хуулиар хориглодог гэдгийг 100% мэдэж байгаа нь бусад аймгуудтай харьцуулахад энэ нутгийн www.wwf.mn

иргэд ан агнуурын хуулийн талаар арай илүү мэдлэгтэй нь харагдаж байна. Гэхдээ танд агнах зөвшөөрөл хэрэгтэй юу гэсэн асуултанд 67.9% нь “тийм” гэж хариулсан байгаа нь цоохор ирвэсний аль нэг эрхтэнг эмийн зорилгоор ашигладаг гэж 54.2% нь хариулсан нь хууль бус агнуур байгааг илтгэж байна.

4.Баянхонгор аймаг

Судалгаанд тус аймгийн Баян-Овоо, Галуут, Эрдэнэцогт, Шинэжинст, Баянхонгор сумын 137 иргэн хамрагдан оролцсон (Зураг 4).

Зураг 4. Судалгаанд хамрагдсан газар



Баянхонгор аймгаас судалгаанд хамрагдсан нутгийн иргэдийн 76 буюу 57% нь цоохор ирвэсний амьдрах орчинтой ямар нэгэн хэмжээгээр давхцдаг. Цоохор ирвэсийг судалгаанд оролцогчдын 77% нь өсөөгүй, 23% нь өссөн гэж үнэлсэн.


Диаграмм 2.



Судалгаанд оролцсон хүмүүсийн 57 нь буюу 59.4% нь өвөл, 21 нь буюу 21.9% нь зуны улиралд цоохор ирвэсний амьдрах орчинд ойр нутагладаг бөгөөд хавар, намарт ч 9.4% нь ирвэстэй нутгуудад амьдарч байгаагаас гадна

жилийн дөрвөн улирлын туршид малын бэлчээр, цоохор ирвэсний амьдрах орчин давхцаж байгаа юм (График 9).


График 9



Нийт оролцогчдын 77.5% нь цоохор ирвэс уствал байгальд сөрөг нөлөөтэй гэж хариулсан боловч яг ямар сөрөг нөлөө вэ? гэдгийг мөн л хариулж чадахгүй байгаа билээ. Ховордож байгаа гол шалтгаан нь хулгайн анчид олширсон гэж хариулсан. Энэ нь хууль бус агнуур их байгааг тодорхой харуулж байна.


Цоохор ирвэс малд халдаж байгаа шалтгааныг судалгаанд оролцогчдын 72.5% нь идэш тэжээлийн хомсдлоос, 6.1% нь тоо толгой нь эрс нэмэгдсэн учраас, 21.5% нь малын тоо толгой өссөнтэй холбоотой гэж үзжээ (График 10).

График 10



Цоохор ирвэсний үндсэн идэш тэжээл болох янгир ямааны тоо толгой буурах шалтгааныг авч үзвэл 59.8% нь махчин амьтдын тоо толгой олширсноос, 40.2% нь малын тоо толгой нэмэгдсэн гэж үзжээ (График 11).

График 11




Баянхонгор аймгаас судалгаанд оролцогчид Цоохор ирвэс агнахыг хуулиар хориглодог гэдгийг 100% мэддэг, харин агнах зөвшөөрөл 77.6%-д нь хэрэгтэй гэж хариулсан. Цоохор ирвэсний аль нэг эрхтэнг эмийн зорилгоор ашигладаг уу гэсэн асуултанд 36.9% нь тийм гэсэн хариулт өгчээ.

5.Баян-Өлгий аймаг

Судалгаанд тус аймгийн Толбо, Дэлүүн, Бугат, Цэнгэл, Өлгий сумын 187 иргэн хамрагдан оролцсон (Зураг 5).


Зураг 5. Судалгаанд хамрагдсан нутаг



Баянхонгор аймгаас судалгаанд хамрагдсан нутгийн иргэдийн 25% нь цоохор ирвэсний амьдрах орчинтой ямар нэгэн хэмжээгээр давхцдаг.


Цоохор ирвэсийн хамгаалал, экологийн талаарх сургалт сурталчилгааг Баян-Өлгий аймагт жилийн турш явуулах шаардлагатай бөгөөд зуны улиралд малын бэлчээр, цоохор ирвэсний нутаг хамгийн их буюу 63.6 хувь нь давхцдаг байна (График 12).

График 12




Баян-Өлгий аймагт цоохор ирвэс малд халдаж байгаа шалтгааныг судалгаанд оролцогчдын 54% нь идэш тэжээлийн хомсдлоос, 13.04% нь тоо толгой нь эрс нэмэгдсэн учраас, 32.9% нь малын тоо толгой өссөнтэй холбоотой гэж үзжээ (График 13).

График 13



Баян-Өлгий аймагт янгир ямааны тоо толгойд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг авч үзвэл 30.39% нь малын тоо толгой нэмэгдсэнээс, 69.79.% нь махчин амьтдын тоо толгой олширсноос гэж үзсэн байна (График 14).

График 14



Баян-Өлгий аймгаас судалгаанд оролцогчдын 38.5% нь цоохор ирвэсийг агнаж болохгүй гэж үзэж байгаа үлдсэн хэсэг нь агнах зөвшөөрлийг БОЯ болон Засгийн газар олгодог хэмээн хариулсан байна. Мөн агнаж болох хугацааны талаар 2 оролцогч тодорхой хэмжээний мэдлэгтэй байгаа нь энэ аймагт хууль бус агнуур хийгдэх нөхцөл байгааг харуулж байна. Цоохор ирвэсний эд, эрхтэний хэсгийг анагаах ухаанд ашиглаж ирсэн эсэх талаар нутгийн иргэд эртний ямар нэгэн мэдлэгтэй байгаа бөгөөд Баян-Өлгий аймгаас судалгаанд оролцогчдын 20% нь ашиглаж ирсэн, 80% нь ашигладаггүй гэсэн хариулт өгсөн.




Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан аймгуудыг дараах байдлаар харьцуулан дүгнэв. Үүнд:

1. **Цоохор ирвэс бүхий нутаг малын бэлчээртэй давхцах хамгийн их эрсдэлтэй улирлуудыг аймаг бүрээр харьцуулж үзэхэд хаврын улиралд Ховд аймгаас судалгаанд оролцогчдын 57.3%, намрын улиралд Говь-Алтай аймгаас судалгаанд оролцогчдын 56.4% нь цоохор ирвэс бүхий нутгуудад оршин суудаг. Цоохор ирвэс бүхий нутагт хүн хамгийн олноороо оршин суудаг улирал нь өвөл, зун бөгөөд жилийн туршид хамгаалах үйл ажиллагаа болон сурталчилгааг хийх шаардлагатай нь харагдаж байна (Хүснэгт 1).**

Хүснэгт 1.Цоохор ирвэс бүхий нутагт ойр амьдардаг хүмүүсийн судалгаа /улирлаар/

№	Аймгийн нэр	Өвөл		Хавар		Зун		Намар	
		Хүн	%	Хүн	%	Хүн	%	Хүн	%
1	Баянхонгор	57	20.9	9	12	21	9.4	9	14.5
2	Баян-Өлгий	13	4.8	4	5.4	42	18.8	7	11.4
3	Говь-Алтай	104	38.1	19	25.3	74	33.0	35	56.4
4	Увс	0	0	0	0	26	11.6	0	0
5	Ховд	99	36.1	43	57.3	61	27.2	11	17.7
	Нийт	273	100	75	100	224	100	62	100



2. Цоохор ирвэсийг хамгаалах болон хууль бус агнуурын талаар
тандсан асуулгын үр дүнг 2-р хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 2.Цоохор ирвэсний хамгаалал болон хууль бус агнуурын тандалт
/аймгаар/




Асуулт	Баянхонгор		Баян-Өлгий		Говь-Алтай		Увс		Ховд	
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Цоохор ирвэсийг хамгаалах ашигтай юу?	80	30	139	33	226	34	25	2	122	24
Цоохор ирвэсний арьс худалдаалах зөвшөөрлийг авах хэрэгтэй юу?	2	55	187	72	10	159	2	9	3	28
Цоохор ирвэсийг агнах хуулийн хугацааг мэдэх үү?	0	77	2	59	0	194	0	26	1	85
Цоохор ирвэс агнах зөвшөөрөл танд хэрэгтэй юу?	90	26	124	38	256	22	19	9	95	55
Цоохор ирвэсний аль нэг эрхтэнийг өвчин анагаахад ашигладаг уу?	34	58	41	165	102	109	13	11	56	75

Судалгаанд оролцогчдын 82.8% нь цоохор ирвэсийг хамгаалах нь зүйтэй, 17.2% нь хамгаалах шаардлагагүй гэж үзсэн байна. Мөн ирвэсний арьсыг хууль бус худалдаалдаг эсэхийг тандсан асуултанд 38.7% агнахад зөвшөөрөл авах талаар ямар нэгэн хэлбэрээр хариулж байгаа нь хулгайгаар ан хийх нь бүрмөсөн зогсохгүй байгааг харуулж байна.

Цоохор ирвэсийг хууль бусаар агнаж байгаа эсхийг тодорхойлох шууд бус асуултын үр дүнд агнахад агнуурын зөвшөөрөл хэрэгтэй гэж үзсэн оролцогчдын 34.8% нь Говь-Алтай, 16.8% нь Баян-Өлгий, 12.9% нь Ховд, 5.1% нь Увс, 12.2% нь Баянхонгорын харъяатууд юм. Ер нь хууль бус агнуурын хяналтыг Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймгуудад чангатгах нь зүйтэй.


Цоохор ирвэсний эд эрхтэнийг ашиглаж ирсэн байдлыг авч үзвэл 41.5% нь Говь-Алтай, 22.8% нь Ховд, 16.7% нь Баян-Өлгий, 13.8% нь Баянхонгор, 5.2% нь Увс аймагт тус тус ногдож байгаагаас үзвэл хэрэглээ өндөртэй эхний 3 аймагт мөн л Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий орж байна.

3.Цоохор ирвэсний арьсыг хувийн ашиг сонирхолын үүднээс агнаж ашигладаг аймаг бол Баян-Өлгий бөгөөд “ирвэсний арьс хадгалагдаж байгаа” гэсэн мэдээллийг тус амйгаас судалгаанд оролцогчдын 25% нь өгч байна. Мөн Баянхонгор, Ховд, Увс аймгуудад ч ирвэсний арьс хувь хүмүүсийн гар дамжиж байна гэсэн мэдээг судалгаанаас олж авлаа.



4. Цоохор ирвэсний тоо толгойн байдалд өгсөн үнэлгээг 5 аймгаар харьцуулж үзэв (График 16).

График 16



Судалгаанд оролцсон хүмүүсийн 49.7% нь цоохор ирвэсний тоо толгой өссөн, 50.3% нь өсөөгүй /хэвийн, буурсан/ гэж үзсэн байна. Үүнээс Говь-Алтай, Ховд аймгийн иргэд цоохор ирвэсийг сүүлийн жилүүдэд өсөж байна гэж үнэлсэн байна. Гэрийн мал цоохор ирвэсэнд өртөх тохиолдол ч дээрх 2 аймагт илүү байна гэж үнэлэгдсэн нь цоохор ирвэсний тоо толгойг үүнтэй шууд холбож үнэлсэн байх талтай.

Зөвлөмж

1. Цоохор ирвэсийн гол тархац нутгийг хамардаг Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор аймгийн иргэдийн дунд Цоохор ирвэсний экологи хамгааллын талаар судалгаанд оролцогчдын 52.82% нь тодорхой хэмжээний мэдлэгтэй, 47.2% нь огт мэдлэггүй байна. Гэвч хуулийн тодорхой заалтууд болон яагаад хамгаалах шаардлагатай талаар өөрсдийн үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар дутмаг байгаагийн гол шалтгаан нь хамгаалах ажлыг эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, иргэдэд ойлгомжтой хэлбэрээр сурталчилж чадахгүй байгаатай шууд холбоотой байж болно.
2. Дээрх нутгуудад газар ашиглалтын менежмент төлөвлөгөө жинхэнэ утгаараа хэрэгждэггүй учраас бэлчээрийн давхцал ихтэй үүний улмаас цоохор ирвэс, янгир ямаа зэрэг ховор, нэн ховор амьтад дайжих, тоо

толгой нь цөөрөх улмаар цоохор ирвэс малд халдах гол нөхцөл болж байна. Энэ нь өвөл, хаврын улиралд малын бэлчээр, зэрлэг амьтдын амьдрах нутаг шууд давхцаж байгаатай ч салшгүй холбоотой тул газар ашиглалтын менежмент төлөвлөгөөнд зэрлэг амьтдын байршил нутгийг тусгаж өгөх нь зүйтэй.

3. Судалгаанд хамрагдсан иргэдэд Цоохор ирвэсийн талаарх хуулийн болон хамгаалалтай холбоотой нэр томъёо, ухагдахуунуудыг хялбаршуулсан хэлбэрээр хүргэх шаардлагатай бөгөөд энэ үйл ажиллагааг “Ногоон сургууль”, “Ирвэс интерпрайз” хөтөлбөрүүдээр дамжуулан бүх шатны хүмүүст хүргэх боломж нээлттэй байна. Өөрөөр хэлбэл орон нутгийнханд хамгийн ойр байгаа мэдээлэл түгээх систем нь одоогийн түвшинд энэ 2 хөтөлбөрт хамрагдсан иргэд юм.
4. Цоохор ирвэс хамгаалах сургалт, сурталчилгааны ажлыг Говь-Алтай аймагт өвлийн улиралд, Ховд, Баянхонгор, Увс, Баян-Өлгий аймгуудад өвөл зуны улирлуудад хийх нь тохиромжтой байна. Эдгээр нутгуудад цоохор ирвэсийг хамгаалах биоэкологийн болон хууль эрх зүйн үндэслэлийг сурталчлах, ухуулан тайлбарлах ажил дутмаг эсвэл тэдэнд мэдээлэл хүргэж буй арга хэлбэр нь тохирохгүй байгааг илтгэж байгааг цаашид анхаарах шаардлагатай. Уг ажилдаа дараах нөхцөлүүдийг анхаарах хэрэгтэй юм. Үүнд:
 - Малчдад бэлчээрийн нөөцийг зөв ашиглах нэгдсэн менежмент төлөвлөгөөгүй байгаа нь цаашдаа бусад зэрлэг амьтдад сөрөг нөлөө шууд үзүүлнэ.
 - Малчид өөрсдийн амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргээ хязгааргүйгээр өсгөх сонирхолтой болсон.
 - Зэрлэг амьтдын тархац нутгийг мал сүрэг эзлэн талхлагдалд оруулж улмаар цоохор ирвэс болон бусад махчин амьтдын идэш тэжээл олзворлодог нутагт малын тоо толгой өссөн нь халдахаас өөр аргагүй байдалд хүргэсэн.